



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/1/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2023 оны 02 дугаар сарын 17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЕБНС	Ерөнхий боловсролын Номгон сургууль



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/60
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номгон сургууль байгуулагдсаны 60 жилийн тохиож төгсөгчдөөс 93,933.2 мянган төгрөгийн хөрөнгө хандивласныг тайландаа бүртгэж тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 3 үндсэн зорилтын хүрээнд 8 чиглэлээр 31 арга

005020278

хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Баянхонгор сумын Засаг дарга 94.0 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>249,997,168.75</u>	<u>454,170,239.65</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	98,331,919.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	98,331,919.00
3121	Төгрөг	00.00	98,331,919.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	98,331,919.00
33	АВЛАГА	3,002,348.00	1,282,953.01
335	Бусад авлага	3,002,348.00	1,282,953.01
3351	Байгууллагаас авах авлага	3,002,348.00	1,182,953.01
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	246,994,820.75	354,555,367.64
351	Түүхий эд материал	110,199,416.11	162,584,960.08
35110	Тусгай зориулалттай материал	84,390,106.11	149,413,560.08
35130	Эм боох материал	25,809,310.00	13,171,400.00
354	Хангамжийн материал	136,795,404.64	191,970,407.56
35410	Бичиг хэргийн материал	8,368,800.00	9,941,000.00
35420	Аж ахуйн материал	11,494,361.00	16,755,916.00
35450	Барилгын засварын материал	1,454,000.00	1,454,000.00
35460	Хүнсний материал	00.00	46,300.00
35470	Бусад хангамжийн материал	115,478,243.64	163,773,191.56
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,606,257,434.75</u>	<u>2,880,305,473.86</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,606,257,434.75	2,880,305,473.86
392	Биет хөрөнгө	1,790,865,768.01	2,065,973,182.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,728,173,183.90	1,728,145,183.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-236,409,535.87	-319,135,591.47
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	553,156,521.63	833,001,298.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-435,658,798.16	-435,971,206.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	231,227,798.06	329,065,825.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-113,067,771.55	-133,560,198.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,413,358.00	32,413,358.00
39217	Ном	31,031,012.00	32,014,512.00
393	Биет бус хөрөнгө	815,391,666.74	814,332,291.82
39301	Программ хангамж	8,492,798.00	8,767,798.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,676,131.26	-7,010,506.18
39303	Бусад биет бус хөрөнгө	812,575,000.00	812,575,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,856,254,603.50</u>	<u>3,334,475,713.51</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>39,901.82</u>	<u>6,932,145.75</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	39,901.82	6,932,145.75
413	Өглөг	39,901.82	6,932,145.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	6,932,145.75
4136	Бусад өглөг	39,901.82	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	39,901.82	00.00

Баянхонгор аймгийн Ерөнхий Боловсролын Номгон сургууль
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,856,214,701.68</u>	<u>3,327,543,567.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,856,214,701.68	3,327,543,567.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,498,705,779.83	2,498,705,779.83
51101	Өмч: - төрийн	2,498,705,779.83	2,498,705,779.83
512	Хуримтлагдсан үр дүн	-2,797,911,381.48	-2,326,582,515.40
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,797,911,381.48	-2,797,911,381.48
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	471,328,866.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,155,420,303.33	3,155,420,303.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,856,254,603.50</u>	<u>3,334,475,713.51</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,149,957,046.26	4,210,318,820.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	241,696,418.26	422,450,520.88
120	Нийтлэг татварын бус орлого	241,696,418.26	422,450,520.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	487,977.00	4,594,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,594,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	452,977.00	00.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	17,714,114.20	87,900,590.88
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	223,494,327.06	329,955,930.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	508,056,028.00	3,787,868,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	3,189,796,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	3,189,796,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,400,204,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	144,271,964.00	20,747,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	144,271,964.00	2,022,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	18,725,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	363,784,064.00	577,324,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	363,784,064.00	577,324,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,962,487,550.58	3,738,989,954.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,962,487,550.58	3,738,989,954.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,723,065,478.58	3,643,623,484.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,917,297,692.00	2,358,992,037.00
210101	Үндсэн цалин	1,556,541,024.00	1,700,131,658.00
210102	Нэмэгдэл	360,756,668.00	604,947,444.00
210104	Урамшуулал	00.00	30,849,802.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	23,063,133.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,627,427.93	297,113,247.74

Баянхонгор аймгийн Ерөнхий Боловсролын Номгон сургууль 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210201	Тэтгэврийн даатгал	174,204,932.93	208,703,733.42
210202	Тэтгэмжийн даатгал	19,454,764.00	22,575,595.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,446,209.00	18,268,066.35
210204	Ажилгүйдлийн даатгал	3,683,774.00	4,320,937.53
210205	Эрүүл мэндийн даатгал	36,837,748.00	43,244,915.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	352,309,360.00	486,803,338.00
210301	Гэрэл, цахилгаан	9,304,086.00	25,164,268.00
210302	Түлш, халаалт	308,103,442.00	417,793,028.00
210303	Цэвэр, бохир ус	34,901,832.00	43,846,042.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,872,060.82	44,664,160.18
210401	Бичиг хэрэг	4,867,400.00	20,386,360.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	701,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,738,908.82	99,598.18
210404	Ном, хэвлэл	132,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,569,932.00	14,361,002.00
210408	Бараа материал акталсны зардал	1,363,820.00	9,116,200.00
2105	Нормативт зардал	12,920,910.00	213,858,525.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,920,910.00	13,683,130.00
210502	Хоол, хүнс	00.00	200,175,395.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,750,800.00	20,163,975.00
210604	Урсгал засвар	18,750,800.00	20,163,975.00
2107	Томилолт, зочны зардал	685,000.00	915,000.00
210702	Дотоод албан томилолт	685,000.00	915,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,984,800.00	21,419,385.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,342,800.00	10,114,180.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,000.00	11,305,205.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,617,427.83	199,693,816.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,135,598.00	36,882,665.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,363,800.00	2,876,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,118,029.83	159,935,150.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	239,422,072.00	95,366,470.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	190,523,122.00	81,994,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	64,176,100.00	81,994,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	82,358,207.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,182,634.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,806,181.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,895,700.00	00.00
213404	Хөрөнгийн	1,895,700.00	00.00

Баянхонгор аймгийн Ерөнхий Боловсролын Номгон сургууль 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,003,250.00	13,371,970.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,003,250.00	13,371,970.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	187,469,495.68	471,328,866.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	505,144,281.60	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	505,144,281.60	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-505,144,281.60	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-317,674,785.92	471,328,866.08

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,908,748,605.00	3,792,462,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	487,977.00	4,594,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	487,977.00	4,594,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	487,977.00	4,594,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,594,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	452,977.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,908,260,628.00	3,787,868,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	3,189,796,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	3,189,796,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,400,204,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	144,271,964.00	20,747,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	144,271,964.00	2,022,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	18,725,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	363,784,064.00	577,324,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	363,784,064.00	577,324,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,870,793,605.00	3,590,103,121.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,870,793,605.00	3,590,103,121.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,631,437,914.00	3,348,558,556.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,910,373,243.00	2,351,502,743.57
210101	Үндсэн цалин	1,369,539,079.00	1,694,950,498.57
210102	Нэмэгдэл	405,505,803.00	602,639,310.00
210104	Урамшуулал	135,328,361.00	30,849,802.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	23,063,133.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	259,231,300.00	293,256,134.43

Баянхонгор аймгийн Ерөнхий Боловсролын Номгон сургууль 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210201	Тэтгэврийн даатгал	193,686,100.00	203,542,050.72
210202	Тэтгэмжийн даатгал	16,670,100.00	21,285,152.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,427,700.00	16,575,130.31
210204	Ажилгүйдлийн даатгал	3,106,900.00	4,030,560.12
210205	Эрүүл мэндийн даатгал	33,340,500.00	47,823,240.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	352,784,064.00	486,328,634.00
210301	Гэрэл, цахилгаан	9,778,790.00	24,689,564.00
210302	Түлш, халаалт	308,103,442.00	417,793,028.00
210303	Цэвэр, бохир ус	34,901,832.00	43,846,042.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,384,507.00	00.00
210401	Бичиг хэрэг	2,880,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,699,007.00	00.00
210404	Ном, хэвлэл	286,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,319,500.00	00.00
2105	Нормативт зардал	5,455,520.00	54,043,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,685,000.00	00.00
210502	Хоол, хүнс	00.00	54,043,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,770,520.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,785,900.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	27,785,900.00	20,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	685,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	685,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,262,200.00	32,378,655.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,422,200.00	11,089,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	21,289,655.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,476,180.00	111,048,789.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,398,380.00	79,163,789.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,077,800.00	31,885,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	239,355,691.00	241,544,565.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	190,456,741.00	228,172,595.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	64,176,100.00	228,172,595.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	82,358,207.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,182,634.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,739,800.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,895,700.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,895,700.00	00.00

Баянхонгор аймгийн Ерөнхий Боловсролын Номгон сургууль
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,003,250.00	13,371,970.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,003,250.00	13,371,970.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>37,955,000.00</u>	<u>202,359,179.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,955,000.00	104,027,260.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,955,000.00	104,027,260.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,955,000.00	104,027,260.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,955,000.00	104,027,260.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-37,955,000.00</u>	<u>-104,027,260.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	98,331,919.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	98,331,919.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,705,779.83	3,155,420,303.33	-2,797,911,381.48	00.00	2,856,214,701.68
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,705,779.83	3,155,420,303.33	-2,797,911,381.48	00.00	2,856,214,701.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,498,705,779.83	3,155,420,303.33	-2,797,911,381.48	00.00	2,856,214,701.68
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	471,328,866.08	00.00	471,328,866.08
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,705,779.83	3,155,420,303.33	-2,326,582,515.40	00.00	3,327,543,567.76

Баянхонгор аймгийн Ерөнхий Боловсролын Номгон сургууль
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,208,823,800.00	3,111,510,881.00	97,312,919.00	97.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,208,823,800.00	3,111,510,881.00	97,312,919.00	97.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,974,266,500.00	2,883,338,286.00	90,928,214.00	96.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,371,932,400.00	2,300,143,401.57	71,788,998.43	97.0
210101	Үндсэн цалин	1,765,789,400.00	1,671,386,822.57	94,402,577.43	94.7
210102	Нэмэгдэл	569,823,100.00	597,906,777.00	-28,083,677.00	104.9
210104	Урамшуулал	36,319,900.00	30,849,802.00	5,470,098.00	84.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	296,491,700.00	286,991,580.43	9,500,119.57	96.8
210201	Тэтгэврийн даатгал	201,614,300.00	198,833,528.57	2,780,771.43	98.6
210202	Тэтгэмжийн даатгал	23,719,400.00	20,984,738.72	2,734,661.28	88.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,975,500.00	16,351,599.19	2,623,900.81	86.2
210204	Ажилгүйдлийн даатгал	4,743,900.00	3,979,743.92	764,156.08	83.9
210205	Эрүүл мэндийн даатгал	47,438,600.00	46,841,970.03	596,629.97	98.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,746,100.00	27,358,655.00	3,387,445.00	89.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,700,000.00	5,794,000.00	-1,094,000.00	123.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,046,100.00	21,564,655.00	4,481,445.00	82.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221052700.00	214801049.00	6,251,651.00	97.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	181,983,600.00	175,732,549.00	6,251,051.00	96.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,069,100.00	39,068,500.00	600.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234557300.00	228172595.00	6,384,705.00	97.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	234,557,300.00	228,172,595.00	6,384,705.00	97.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	234,557,300.00	228,172,595.00	6,384,705.00	97.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,208,823,800.00	3,208,642,800.00	181,000.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,700,000.00	4,594,000.00	106,000.00	97.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,700,000.00	4,594,000.00	106,000.00	97.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	98,331,919.00	-98,331,919.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,576,700.00

Баянхонгор аймгийн Ерөнхий Боловсролын Номгон сургууль 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,576,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,576,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,576,700.00
210604	Урсгал засвар	5,576,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,576,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,576,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,576,700.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номгон сургууль нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хуулийн дагуу нийгмийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Ерөнхий боловсролын Номгон сургууль нь Захиргаа аж ахуй, нийгмийн ухаан, байгалийн ухаан, бага боловсролын сургалтын алба гэсэн бүтэцтэй, нийт 72 бүлэг, 2478 суралцагч, 152 орон тоотой үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт 3,786,148 .3 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн зорилго зорилт нь Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх зорилго дэвшүүлж ажилласан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Захирал Л.Сарангэрэл, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Цэрэндолгор нар зурж, нярваар Д.Мөнх-Эрдэнэ, Б.Мягмар, Б.Цолмон нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал,
- Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор цалингийн шатлал,
- Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 192 дүгээр тогтоолоор цалингийн шатлал,
- БШУС-ын 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А/122 тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ЕБС-ийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээ,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал
- БШУС-ын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 2022 оны 1, 2, 3 дугаар улирлыг хамруулан шалгалт хийсэн харин санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн захирлын 2018 оны А/21 тоот тушаалаар баталсан “Төсвийн байгууллага, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 3,334,475.7 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 478,221.0 мянган төгрөгөөр буюу 116.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	98,331.9	98,331.9
Авлага	3,002.3	1,282.9	(1,719.4)
Бараа материал	246,994.8	354,555.3	107,560.5
Үндсэн хөрөнгө	3,397,069.6	3,775,982.9	378,913.3
Хуримтлагдсан элэгдэл	(790,812.2)	(895,677.5)	(104,865.3)
Нийт хөрөнгө	2,856,254.6	3,334,475.7	478,221.0
Өр төлбөр	39.9	6,932.1	6,892.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,856,214.7	3,327,543.6	471,328.8

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,856,254.6	3,334,475.7	47,822.1
--	--------------------	--------------------	-----------------

Дээрх хүснэгтээс харахад, Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 98,331.9 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Тайлант оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлийн 2,527.6 мянга, Баянхонгор эрчим хүч ЦТХХК-иас 474,7 мянга нийт 3,002.3 мянган төгрөг авлагатай, тайлант хугацаанд 277,119.1 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, 279,857.5 төгрөгийн авлагыг барагдуулж, тайлант оны эцэст Нийгмийн даатгалын шимтгэлийн 163.9 мянга, түрээсийн сурах бичгийн 1,182.9 мянга, нийт 1,282.9 мянган төгрөгийн авлагатай ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 354,555.3 мянган төгрөг болж өмнөх оноос 107,560.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 237,433.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, улсын төсвөөс 17,505.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, бусад байгууллага хүмүүсийн хандиваар 70,395.2 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч үйл ажиллагаандаа 208,657.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан ба 9,116.2 мянган төгрөгийн бараа материалыг Захирлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Эргэлтийн хөрөнгө актлах тухай” А/47 дугаар тушаалаар акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,775,982.9 мянган төгрөг болж 478,221.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 104,027.2 мянга, БШУЯ-аас 3,981.5 мянга, хандиваар 93,933.2 мянга, БШУЕГ-аас 227,848.2 мянга, АЗДТГ-аас 2,386.0 мянга, Дэлхийн зөн ОУБ-аас 1,807.0 мянга нийт 433,983.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 9/29 тоот тогтоолоор 55,069.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Тайлант оны эхэнд холбооны зардлын 39.9 мянган төгрөгийн өр төлбөртэй байсныг барагдуулж, тайлант оны эцэст ХХОАТ-ын 6,892.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласнаас шалтгаалсан байна.

Нийт авлага, өглөгийг харилцагч байгууллага, хувь хүмүүстэй тооцоо нийлсэн актаар баримтыг үйлдэж баталгаажуулсан.

Тайлангийн хугацаанд 8,151,807.7 мянган төгрөгийн өглөгийг хоорондын тооцоогоор бүртгэж 6,932.1 мянган төгрөгийн өглөгийг баталгаажуулсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 471,328.8 мянган төгрөгөөр өсөж 3,327,543.5 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,741,366.2 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 10,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 685,381.7 мянган төгрөг, нийт зарлагыг 4,436,747.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд 6 удаа тодотгол хийж 650,599.6 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 3,189,796.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоор 19,027.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 577,324.5 мянган төгрөг, нийт 3,786,148.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,189,796.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоор 19,027.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 577,324.5 мянган төгрөг, нийт 3,786,148.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,189,796.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогыг 2,305.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлж 12,305.0 мянган төгрөгийн зарцуулах эрх, дээд шатнаас төвлөрүүлэх орлогыг 6,722.8 мянган төгрөгөөр зарцуулах эрх олгосноос, улсын төсвийн санхүүжилтээс 98,331.9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг дансанд мөнгөн хөрөнгөөр үлдээсэн.

Орон нутгийн төсвөөс 577,324.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 563,952.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийж 13,371.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,110,491.9 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 98,331.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	3,208,823.8	3,110,491.9	98,331.9	96.9%
1.1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	10,418.4	10,418.4	0.00	100%
1.2	80312 Сургалт семинар	5,209.2	5,191.1	18.1	99.7%
1.3	81605 Эрүүл мэндийг дэмжих	11,981.2	5,891.0	6,090.2	49.2%
1.4	81801 Үдийн цай хөтөлбөр	288,600.9	282,216.1	6,384.7	97.8%
1.5	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	106,395.0	106,297.7	97.2	99.9%
1.6	81823 Боловсролын байгууллагын багш	23,441.5	23,438.5	2.9	100%
1.7	81834 Боловсролын стандарт	2,578,885.9	2,507,123.1	71,762.7	97.2%
1.8	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	164,863.9	150,881.1	13,975.7	91.5%
1.9	81844 Гүнзгийрүүлсэн сургалт	12,305.00	13,429.8	-1,124.8	109.1%
1.10	81848 Түрээсийн сурах бичиг	4,700.0	4,594.0	106.0	97.7%

Баянхонгор аймгийн Ерөнхий Боловсролын Номгон сургууль
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1.11	83603 Дээд шатны байгууллагаас	2,022.8	2,022.8	0.00	100%
2	71802 Ерөнхий боловсрол	577,324.5	577,324.5	0.00	100%
2.1	80112 Нийтлэг үйлчилгээ	577,324.5	563,952.5	13,371.9	97.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гүнзгий ангийн төлбөр 5,295.0 мянган төгрөг төвлөрснөөс 3,676.5 мянган төгрөгийг зарцуулж 1,618.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны данс руу шилжүүлж нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургууль нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын Номгон сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 5 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,705,461.8 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,705,461.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 56,976.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн

материаллаг байдлын 70 хувиар буюу 39,883.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,752.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,357.1 мянга, мэдээлэл технологийн зардлыг 4,481.4 мянга нийт 23,590.9 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 148 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, боловсролын салбарын 2022 оны батлагдсан төсөв тодорхой шалтгааны улмаас хугацаа хоцорсноос шалтгаалан 1 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд дулаанаар хангах, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, үдийн цай, хүнсний материал худалдан авах, мах махан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж худалдан авах 7 гэрээний 829,969.3 мянга, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн 3,688,040.6 мянган төгрөгийн 67 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 825,616.1 мянган төгрөгийн 37 гүйлгээ, хүний нөөц, өмч хөрөнгө, санхүүтэй холбоотой 249,037.9 мянган төгрөгийн 110 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 79,079.9 мянган төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 47,357.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, мэдээллийг хугацаанд нь цахим хуудаст үнэн зөв дүнгээр байршуулж буйд тавих төсвийн шууд захирагчийн хяналтыг сайжруулах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 777.3 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан, 1,531.9 мянган төгрөгийн албан шаардлага, 55,213.3 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 27 тоот албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	1,531.9	1	1,531.9	100
Төлбөрийн акт	1	777.3	1	777.3	100
Зөвлөмж	1	55,213.3	1	55,213.3	100
Нийт дүн	3	57,522.5	3	57,522.5	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БСШУСС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар Үдийн цай хөтөлбөрийн зардал 6,384.7 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

. Аудитаар нийт 16,424.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 238.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 16,186.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тайлант хугацаанд томилолтын зардлыг анхан шатны баримттай тулгахад багш Г:Ууганбаярт 32.0 мянга, Ц.Ариунсанд 16.0 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон, цалингийн урьдчилгааг суутгасан урьдчилгаатай тулгахад Захиргаа аж ахуйн дарга Д.Долгорсүрэнгээс 100.0 мянган төгрөгийн дутуу суутгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд томилолтын зардалд илүү олгосон 79.5 мянга, цалингийн урьдчилгаанаас дутуу суутгасан 100.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Тус байгууллага нь 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хэвлэл захиалгын үнэнд 40.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.3 “хэвлэлийн захиалгын төлбөр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж хэвлэл захиалгын үнэнд шилжүүлсэн 40.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3. Мэдээлэл технологийн зардлаас захиралд датаны үнэнд нийт 50.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд хууль, журам зөрчиж зориулалт бусаар зарцуулсан 50.0 мянган төгрөгийг төсөв захирагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Өр төлбөрийн холбоотой асуудал

5.3.1. Тайлант онд ТАЦНС-д багш нарын ээлжийн амралтыг 6 дугаар сард бодож 7 дугаар сард зөвхөн ажилтнуудын цалинг бодохдоо багш нарын цалинг татаж бодоогүйгээс ХХОАТ-ын 6,892.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн, цаашид төсвийн шууд захирагч нь төсвийг үр ашигтай удирдаж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Авлагын холбоотой асуудал.

5.3.2. Түрээсийн сурах бичгийн орлогын төлөвлөгөө 4,700.0 мянган төгрөг батлагдсан бөгөөд орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн, тайлант онд гүнзгийн ангийн төлбөрийн орлогоос 10,000.0 мянган төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас 10,775.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба уг орлогоос түрээсийн сурах бичгийн орлогод 1,019.0 мянган төгрөгийг БШУЯ-руу илүү шилжүүлж авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн, цаашид төсвийн шууд захирагч нь төсвийг үр ашигтай удирдаж авлага үүсгэхгүй ажиллах.

Зардлын холбоотой асуудал.

5.3.3. Хичээл практикийн зардлаас цонхны хамгаалалтын төмөр авахад 4,500.0 мянган төгрөг, номын үнэнд 849.7 мянган төгрөг, багш, сурагчдын бүжгийн сургалтын төлбөрт 2,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн ангилал ашиглах заавар”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн “Заавар батлах тухай” А/170 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 190, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалуудыг хэрэгжүүлж, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал.

5.3.4. Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 426.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг и баримтгүй харилцагч байгууллагын дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5. Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6 дахь “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэн цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 79,079.9 мянган төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 47,357.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.	1	0	0	0	0	0
Дүн	1	0	0	0	1	0

00000